



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 5 сарын 23 өдөр

Дугаар 124

Улаанбаатар хот

「 Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа  
эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулахыг  
зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 04 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 6.12 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Гацуурт трейд ҮЦК” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 50,000,000 /тавин сая/ төгрөгөөр нэмэгдүүлж, хавсралтад заасны дагуу хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.


2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг “Гацуурт трейд ҮЦК” ХХК /Ц.Хуяг/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН



Санхүүгийн зохицуулах хорооны  
2019 оны 5 дугаар сарын 23-ны  
өдрийн 126р тогтоолын хавсралт

“Гацуурт трейд ҮЦК” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн  
хэмжээнд оруулсан өөрчлөлт

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцааны нэрлэсэн үнэ /₮/	Хувьцааны эхний үлдэгдэл			Өөрчлөлт		Хувьцааны эцсийн үлдэгдэл		
			Тоо ширхэг	Үнийн дүн /₮/	Эзлэх хувь /%/	Хувьцааны тоо	Үнийн дүн /₮/	Тоо ширхэг	Үнийн дүн /₮/	Эзлэх хувь /%/
1	Л.Чинбат /РД:ШБ62121616/	100	2,375,000	237,500,000	95%	475,000	47,500,000	2,850,000	285,000,000	95%
	Ц.Хуяг /РД:ХП85122671/	100	125,000	12,500,000	5%	25,000	2,500,000	150,000	15,000,000	5%
	Нийт		2,500,000	250,000,000	100%	500,000	50,000,000	3,000,000	300,000,000	100%